



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/12

Хашаат

Ажлын хэсэг байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.3, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 12.2.5 "в"-г үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж өгч ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Дэлгэрсайхан (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Я.Бямбатогтох (Санхүү төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд: Ч.Батхуяг (Санхүүгийн албаны дарга)

С.Мөнхжаргал (Байгаль орчны улсын байцаагч)

Б.Наранцэцэг (Мал үржлийн тасгийн мэргэжилтэн)

М.Норов-Эрдэнэ (3 дугаар багийн Засаг дарга)

А.Ралжигмаа (Хөдөлмөр эрхлэлт, халамжийн

асуудал хариуцсан мэргэжилтэн)

П.Мөнхжаргал (Иргэний төлөөлөл)

Ө.Бямбасүх (Иргэний нийгмийн байгууллага)

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжин хэрэгжих төсөл, арга хэмжээг төлөвлөн боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээг цаг хугацаанд нь чанартай зохион байгуулж санаачилгатай ажиллахыг ажлын хэсгийн гишүүд, ажлын хэсгийн ахлагч (Ц.Дэлгэрсайхан)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2022 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн Ажлын хэсэг байгуулах тухай А/12 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.ОДБАЯР

